



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар СХШ-2025/26

Сүхбаатар сум

Сэлэнгэ аймгийн Бэлчир бүсийн сум  
дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд  
хийсэн хяналт шалгалтын дүн

**НЭГ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМАРСАН ХҮРЭЭ, ХУГАЦАА,  
ШАЛГУУЛСАН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн СХШ-2025/02/ТШЗ дугаартай “Санхүүгийн хяналтын ажлын удирдамж”-аар Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулан зөвлөх зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга СХШУАБ Т.Одсүрэн ахлан, дотоод аудитор Д.Ванчигмаа 2025 оны 11 дүгээр сарын 17-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтаар Бэлчир бүсийн сум дунд ойн ангийн 2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4. Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн нь улсын бүртгэлийн 3759695 дугаар регистртэй, Төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131413002 дугаартай данс, нэмэлт санхүүжилтийн 100131413402 дугаартай данснуудыг ашиглаж байна.

1.5 Тус газрын Төсвийн орлого зарлага, тайлагналт, Төрийн сангийн харилцах дансанд 1-р гарын үсгийг Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга Ж.Эрдэнэцогт 2-р гарын үсгийг нягтлан бодогч Б.Минжээ нар зурж төсвийн хөрөнгийг захиран зарцуулж байна.

1.6 Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны 02 сарын 15 өдрийн А/66 тоот захирамж 8 хүний орон тоо батлагдсанаас одоогийн байдлаар байгууллага нь дарга 1 ойн нягтлан бодогч 1 инженер 1 , техникч 3 , гэсэн 6 оронтойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

4325001174

**Байгууллагын эрхэм зорилго:** Ойн баялгийн нөөцийг судлан тогтоож хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн аж ахуйн арга хэмжээ явуулах тогтвортой менежментийн нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, ойн санг гэрээгээр иргэдийн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах, ойн санд учирсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ хийх, ойн хөнөөлт шавж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын явцад хяналт шинжилгээ хийх, ойжуулалт, ойн аж ахуйн болон ойн ашиглалтын арга хэмжээний шинэ техник, технологийг турших, нутагшуулах, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах, бусад шаардлагатай мэргэжлийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

2024 онд Ойн хөнөөлт шавжийн тархалтыг ойн сан бүхий нутаг болох Алтанбулаг, Шаамар сумдын нутгаар голомттой /голомт нэлэнхийдээ тархана/, няслуур, мөлгөр, эвэрт цохны нисэлт, хусны навч хуйлагч, өрөөсгөл хүр эрвээхэй, бөөс, моносны бүгэг эрвээхэй, бургасны бөөс, цикад, тандалт судалгааг хийж гүйцэтгэхэд нарсны бийрэн сүүлт, сибирийн хүрийн холимог царцаа, нарсны нахиан галл зэрэг хөнөөлт шавж, өвчний шинж тэмдэг судлагдсан. Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Байгаль орчин шавж судлалын нийгэмлэгийн шавж судлаач Д.Алтанчимэг, Н.Ууганбаяр болон сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран тандалт, судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна.

2025 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр Алтанбулаг сумын ойн сангийн 12, 13, 15, 16, 18, 19, 26, 40, 78, 164-р хэсэглэлийн Гүн нуур, Хяраан, Хонд, Мухар төхөм, Хутаг өндөр, Шарвагатай, Хөх өндөр, Гурван цагаан толгой, Гензел, Хангай уул, Ар гуут, Дунд гуут зэрэг газруудын 5000 га талбайд Хатант форест ХХК, Шаамар сумын ойн сангийн 113, 19, 29, 34-р хэсэглэлүүдийн Дулаанхаан уул, Давхар зээргэнэт, Ундрагч, Ээж мод орчим, Шаамар-6, Зөгий, Нарсан сүүл, Цармын эрээн зэрэг газруудын 4000 га талбайд Ойн таксац ХХК нар авиамикробиологийн аргаар сонгомол үйлчилгээт бактерийн бэлдмэл /BT-MN01 биобэлдмэл/ ашиглан агаарын хөлгийн үйлчилгээ үзүүлэгч Томас Эйр ХХК-тай хамтран АН-2 онгоцоор ойн хөнөөлт шавжийн эсрэг тэмцлийн ажлыг гүйцэтгэж ажилласан байна. Тэрбум мод сан Сэлэнгэ аймгийн Засаг даргатай шилмүүст болон навчит модны тарьц худалдан авах гэрээ байгуулсан ба үүнийгээ Алтанбулаг суманд 800 га талбайд ойжуулалт, ойн зурвасын ажил хийлгэж хүлээж авахаар болсон. Энэ ажлын хүрээнд Алтанбулаг сумын Саалийн эрээн, Сэнт чулуу, Өрлөг зэрэг газруудад хавар 400 га талбайд ойн мэргэжлийн байгууллагууд болох Ойн хүрэм ХХК, Өргөн сэлэнгэ ХХК, Говийн улиас ХХК, Бугант номин ХХК-иуд тус бүр 100 га талбайд ойжуулалтын ажил хийж гүйцэтгэсэн. Чагтайн даваа, Цагаан даваа гэх газруудад намар 350 га талбайд ойн мэргэжлийн байгууллагууд болох Агро форест ХХК /200 га/, Өргөн Сэлэнгэ ХХК /100 га/, Ой баясах ХХК /50 га/-ууд хийж гүйцэтгэж ажилласан байна.

1.7 Бэлчир бүсийн сум дундын ойн анги нь Алтанбулаг, сумдын 143,384 га Шаамар сумын 29,860га ойн сан бүхий талбайг хариуцан, сумдын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж байгууллага болон ойн санг гэрээгээр эзэмшигч хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна.

2024 онд 1 хөтөлбөрийн5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 256,098.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 83.5 хувь буюу 213,900.8 мянган төгрөгийг зарцуулж, 16.5 хувь буюу 42,197.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 16,045.0 мянган төгрөгийн, ажил олгогчийн НДШ-ийн зардлаас 2,442.7 мянган төгрөгийн , байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,000.0мянган төгрөгийн,хангамж бараа материалын зардал 3,540.4 мянган төгрөгийн урсгал засвар зардлаас 620.0 мянган төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 1,421.4 мянган төгрөгийн , нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлаас 15,647.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай

## 2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал: /2024 он/

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2024	2024	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	256,098.1	213,900.8	42,197.3	83.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,098.1	213,900.8	42,197.3	83.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,058.0	185,013.0	16,045.0	92.0
210101	Үндсэн цалин	84,586.4	86,184.7	-1,618.3	101.9
210102	Нэмэгдэл	94,264.7	89,168.3	5,096.4	94.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600.0	9,660.0	2,940.0	76.7
210104	Урамшуулал	9,626.9	0.00	9,626.9	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,132.3	22,689.6	2,442.7	90.3
210201	Тэтгэврийн даатгал	17,089.9	15,975.1	1,114.8	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,010.6	1,870.7	139.9	93.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,005.3	1,311.3	-306.0	130.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,005.3	615.9	389.4	61.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,021.2	2,916.7	1,104.5	72.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,000.0	0.00	2,000.0	0.0
210301	Гэрэл, цахилгаан	2,000.0	0.00	2,000.0	0.0

2104	Хангамж, бараа материалын зардал	8,540.0	4,999.6	3,540.4	58.5
210401	Бичиг хэрэг	1,000.0	642.8	357.2	64.3
210402	Тээвэр, шатахуун	6,540.0	4,100.0	2,440.0	62.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500.0	39.8	460.2	8.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500.0	217.0	283.0	43.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.0	380.0	620.0	38.0
210604	Урсгал засвар	1,000.0	380.0	620.0	38.0
2107	Томилолт, зочны зардал	500.0	500.0	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	500.0	500.0	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740.0	318.6	1,421.4	18.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	970.0	0.0	970.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	120.0	120.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100.0	99.6	0.4	99.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50.0	33.0	17.0	66.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500.0	66.0	434.0	13.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,127.8	480.0	15,647.8	3.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,127.8	480.0	15,647.8	3.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,647.8	0.00	15,647.8	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	480.0	480.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	256,098.1	214,380.8	41,717.3	83.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	211,098.1	195,373.7	15,724.4	92.6
320001	Орон нутгийн төсвөөс	211,098.1	195,373.7	15,724.4	92.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	45,000.0	19,007.1	25,992.9	42.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,000.0	19,007.1	25,992.9	42.2
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13.00	13.00	0.0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.0	100.0

2025 онд 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2025 оны 3-р дугаар улирлын байдлаар 153,879.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 96,254.4 мянган төгрөгийг зарцуулж 95.6 хувь буюу 6,737.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 4.4 хувьтай байна

Урсгал зардлын гүйцэтгэлийг ангиллаар нь харьцуулбал: цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас 6,737.8 мянган төгрөгийн, бичиг хэргийн зардлаас 500.0 мянган төгрөгийг үлдэгдэлтэй буюу хэмнэлттэй зарцуулсантай бөгөөд тээвэр холбоотой бөгөөд 6,137.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 4.4 хувьтай байна

Төсвийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал: /2025 он/

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2025оны 3-р улирлын байдлаараа		хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,879.9	147,142.1	6,137.8	95.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,879.9	147,142.1	6,137.8	95.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,279.9	145,542.1	6,737.8	95.6
210101	Үндсэн цалин	73,120.5	71,165.3	1,955.2	97.3
210102	Нэмэгдэл	79,159.4	74,376.8	4,782.6	94.0
2104	Хангамж, бараа материалын зард	1,600.0	1,600.0	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	500.0	0.0	500.0	0.0
210402	Тээвэр, шатахуун	1,100.0	1,600.0	-500.0	145.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.0	100.0

### 2.3. Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт олголтын байдал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Сэлэнгэ аймаг Засаг даргын 2024 оны 02-р дугаар сарын 15 өдрийн А/66 тоот захирамжаар Бэлчир бүсийн сум дундын Ойн ангийн бүтэц орон тоог 8 орон тоотойгоор баталсан боловч 6 орон тоотойгоор ажилласан байна.

Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн даргын тушаал 2025 оны 01-р дүгээр сарын 02 өдөр Б/01 тушаалаар албан хаагчдын цалин шинэчлэн тогтоосон байна. Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлын тушаал шийдвэр, цагийн тооцоо, цалингийн нэгдсэн систем, холбогдох бусад баримт материалтай тулган шалгахад алдаа зерчилгүй байна.

2024 онд албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд цалингийн зардлыг 16,045.5 мянган төгрөг буюу 8 хувь, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2,442.7 мянган төгрөгийн мянган төгрөгийн үлдэгдэлтэй буюу 9,7 хувь хэмнэлттэй байгаа нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна

Цалингийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	2024	2024	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	201,058.0	185,013.0	16,045.0	92.0
210101	Үндсэн цалин	84,566.4	86,184.7	-1,618.3	101.9
210102	Нэмэгдэл	94,264.7	89,168.3	5,096.4	94.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600.0	9,660.0	2,940.0	76.7
210104	Урамшуулал	9,626.9	0.00	9,626.9	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,132.3	22,689.6	2,442.7	90.3
210201	Тэтгэврийн даатгал	17,089.9	15,975.1	1,114.8	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,010.6	1,870.7	139.9	93.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,005.3	1,311.3	-306.0	130.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,005.3	615.9	389.4	61.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,021.2	2,916.7	1,104.5	72.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.0	100.0

2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэлд тулган баталгаажуулалт хийхэд цалингийн зардлыг 6,737.8 мянган төгрөгийн буюу үлдэгдэлтэй буюу 4,4 хувь хэмнэлттэй байгаа нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйтэй холбоотой байна.

Цалингийн гүйцэтгэлийг доорх хүснэгтээр харуулбал:

Код	Үзүүлэлт	2025	2025	хэтрэлт хэмнэлт	Биелэлт хувь
		Батлагдсан Төсөв	гүйцэтгэл		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152,279.9	145,542.1	6,737.8	95.6
210101	Үндсэн цалин	73,120.50	71,165.25	1,955.2	97.3
210102	Нэмэгдэл	79,159.40	74,376.80	4,782.6	94.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6.00	0.0	100.0

620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	0.0	100.0
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	0.0	100.0

Хүснэгт 4

(мянган төгрөгөөр)

Цалин хөлсний тогтоолт, тооцоололтыг тулган баталгаажуулахад: Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

#### **Нэмэлт санхүүжилтийн дансанд:**

2024 онд нэмэлт санхүүжилтийн нь дансанд нь 100131413402 төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 436,4 мянган төгрөг бүрдүүлсэн. Эрхийн бичигт 436,4 мянган төгрөгийн шилжүүлсэн нь зориулалтын дагуу зарцуулсан байна.

2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа нэмэлт санхүүжилтийн нь дансанд нь 100131413402 төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын 13,524.2 мянган төгрөгийг бүрдүүлсэн үлдэгтэй байна.

#### **2.5 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт**

2024-2025 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг хүртэл хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авалт хийдээгүй байна

#### **2.6 Авлага, өр төлбөрийг баталгаажуулж , данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх**

Хяналт шалгалтын хугацаанд тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаагаа зохион байгуулалттай, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, орлого зарлагын тэнцвэрийг ханган ажилласны үр дүнд аливаа өр, авлага үүсгэлгүй, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг бүрэн ханган ажилласан байна.

#### **2.7 Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал**

Бэлчир бүсийн ойн ангийн санхүүгийн тайлангийн аудитыг Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр хамруулж шалгасан бөгөөд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчил өгөгдсөн зөвлөмж байхгүй байна.

#### **2.8 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт Үндсэн хөрөнгө:**

Бэлчир бүсийн сум дундын ойн анги нь 2024 оны эхэнд 220,476.4 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн үлдэгдэлтэй 5,136.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл нэмэгдсэн байна.

2025 оны 3-р дугаар улирлын байдлаар 225,612.4 мянган төгрөгийн /анхны үнээр/ хөрөнгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн бүртгэлд тээврийн хэрэгсэл УАЗ фургон авто марк машин 30,900.0 мянган төгрөгөөр анхны ертгөө бүрэн нөхсөн дахин ашиглах боломжгүй хөрөнгө бүртгэлтэй байна тайлант элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн тээврийн хэрэгсэл нэр дахин ашиглах боломжгүй 30,900.0 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй.

2024-2025 онд Өмч хамгаалах байнгын зөвлөл нь үндсэн хөрөнгө шинээр авч байгаа хөрөнгөд бүрэн бүтэн байдал чанарын шаардлага хангасан дээр 2 удаа хуралдсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоож гарган тухай жилд аймгийн ОНӨГ-т хандаж байхыг зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

### **2.9 Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналт тогтолцоо төлөвшсөн эсэх.**

2024 онд нийт 19 удаагийн мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажлаар 314 га талбайг тусгаарласан ба эдгээрийн мод бэлтгэлийн ажлын үеэр Ойн ангийн инженер, техникч нар аймгийн БОАЖГазар, Цагдаагийн газар, сумын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран нийт 6 удаа технологийн хяналт тавьж ажилласан байна. Хууль бус мод бэлтгэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн ангийн ажилтан албан хаагчид ашиглалтын бүсийн ойн сан бүхий Алтанбулаг сумын БОХУБайцаагч, Байгаль хамгаалагч, Цагдаагийн хэсэгтэй хамтарсан нийт 10 удаагийн эргүүл, шалгалтын ажлыг хийж ажилласан. 2025 оны 3-р улирлын байдлаараа нийт 31 удаагийн мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажлаар 454,62 га талбайг тусгаарласан ба эдгээрийн мод бэлтгэлийн ажлын үеэр Ойн ангийн инженер, техникч нар сумын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран нийт 10 удаа технологийн хяналт тавьж ажилласан байна.

### **2.10 Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг заавар аргачлалын дагуу бүрэн үнэн зөв хөтөлсөн эсэх**

Бэлчир бүсийн сум дундын ойн анги нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь анхан шатны баримт", нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлангаа гаргаж, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлийг зааврын дагуу үнэн зөв хөтөлсөн байна.

### **2.11 Төсөвт төвлөрүүлэх орлогын үндэслэлтэй төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх**

2024 оны ойн нөөц ашигласны орлогын дансанд нийт 62,926.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна 2025 оны 3-р дугаар улирлын байдлаараа Бэлчир бүсийн сум дундын ойн нөөц ашигласны орлогын дансанд нийт 48,807.6 мянган төгрөгийг буюу 85 хувь төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.12 Аймгийн ИТХ-аар баталсан 2024-2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод ,түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоолын хэрэгжилт**

Алтанбулаг сумын Засаг даргын 2024.02.08-ны өдрийн “2023 онд хүчтэй салхи, шуурганы улмаас их хэмжээгээр унасан нарс модыг бэлтгэх тухай” А/15 тоот захирамжийг хэрэгжүүлэн тус сумын Хазай, Цантах, Бөхлөө, Ар, Өвөр дулаан, Саалийн эрээн, Өрлөг чиглэлд их хэмжээгээр унасан нарс модыг БОАЖСайдын 2013 оны А/133 дугаар “Ойгоос мод бэлтгэх журам”-ын 3.5 дахь заалтыг үндэслэн цэвэрлэгээний огтлолтоор бэлтгүүлэхээр болсон ба өнөөдрийн байдлаар 1770,9м<sup>3</sup> хэрэглээ, 106,9 м<sup>3</sup> түлээний мод бэлтгэснийг аж ахуй нэгж байгууллагын дагуу ойн мэргэжлийн байгууллага болон иргэдэд олгож байна

Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн 10 тоот тогтоолыг хэрэгжүүлэн 2025 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай тогтоол 2025 Сумын ИТХ-ын тогтоолын дагуу 2316 м<sup>3</sup> хэрэглээ, 15250 м<sup>3</sup> түлээний мод бэлтгэх хуваарь батлагдсан ба мод бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөн ажиллах, хэрэглээний зориулалтаар болон түлээний модны батлагдсан хуваарийн дагуу 1226,9 м<sup>3</sup> хэрэглээ, 3766 м<sup>3</sup> түлээний мод бэлтгэснийг аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу ойн мэргэжлийн байгууллага болон иргэдэд олгож байна.

### **Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал**

2024 он, 2025 оны 3-р дугаар улирлын төсөв, санхүүгийн болон үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэргийг тулган шалгахад холбогдох хууль, журам, стандартын дагуу хөтлөн явуулж байгаа боловч тэдгээртэй холбоотой хуулийн тогтоомж зөрчих үйлдэл оршсоор байна. Үүнд:

Илрүүлэлт 1. Үндсэн хөрөнгийн бүртгэлд тээврийн хэрэгсэл УАЗ фургон авто марк машин 30,900.0 мянган төгрөгөөр анхны өртгөө бүрэн нөхсөн дахин ашиглах боломжгүй хөрөнгө бүртгэлтэй байна.Тайлант элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн тээврийн хэрэгсэл нэр дахин ашиглах боломжгүй 30,900.0 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган аймгийн ОНӨГ-т хандаагүй.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоож гарган тухай жилд аймгийн ОНӨГ-т хандаж байхыг зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

### **Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:**

#### **4.1 Дүгнэлт:**

4.1 Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын баталсан удирдамжаар Бэлчир бүсийн сүм дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан хугацааны төсөв,

санхүүгийн гүйцэтгэл, бүртгэл тайлагналт, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр "Бага" эрсдэлтэйд тооцож, төсвийн сахилга бат, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж дүгнэлээ.

#### 4.2 Шийдвэрлэлт:

Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт **30,900.0** мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

#### Тав. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч авсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчил нь холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын тэмдэглэлд тусгагдсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн тайланг нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт албан бичгээр ирүүлэхийг дарга, нягтлан бодогч нарт нь хариуцуулав.

**ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**

ДОТООД АУДИТОР

Д.ВАНЧИГМАА

**ХЯНАСАН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Т.МӨНХЗУЛ

**ТАНИЛЦСАН:**

СЭЛЭНГЭ БҮСИЙН СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН

ДАРГА

Ж.ЭРДЭНЭЦОГТ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.МИНЖЭЭ

1319090013 → 3759695

